



УХАТ-ын салбарын гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт

Усны үйлчилгээг зохицуулах зөвлөл
ТЗА-ны дарга Л.Хишигдулам



ХОТ, СУУРИНЫ УС ХАНГАМЖ,
АРИУТГАХ ТАТУУРГЫН АШИГЛАЛТ,
ҮЙЛЧИЛГЭЭГ ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛИЙН
ДАРГЫН ТУШААЛ

2018 оны 01 сарын 12 өдөр

Дугаар А/62

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Тус Зохицуулах зөвлөлийн дүрмийн 2 дугаар зүйлийн 2.1.6, 2.1.9 дэх заалт, Тусгай зөвшөөрлийн гүйцэтгэлийн гэрээний 3.7 дахь хэсгийг үндэслэн Тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж, байгууллагын ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээний тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагын хэрэгжилтийг хангуулах зорилгоор ТУШААХ нь:

1. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагааг дүгнэх журмыг нэгдүгээр, Тусгай зөвшөөрлийн гүйцэтгэлийн гэрээний загварыг хоёрдугаар, Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт /КРП/-ийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Батлагдсан журмын дагуу тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж, байгууллагын тусгай зөвшөөрлийн гэрээ, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг дүгнэх, тайлагнах, үнэлэх арга хэмжээг тухай бүр авч ажиллахыг Тусгай зөвшөөрлийн алба /Л.Хишигдулам/, Үнэ тарифын алба /Ж.Гэрэлчулуун/-нд тус тус үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаал батлагдахтай холбогдуулан 2015 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн А/18 тоот, **2016 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн А/17 тоот тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.**

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрх зүй, мэдээлэл, захиргааны алба /Б.Доржбат/-нд даалгасугай.

ДАРГА



Э.ПҮРЭВЖАВ

00000003

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн даргын 2018 оны 01 дугаар сарын 13-ны өдрийн 11/02 тоот тушаалын нэгдүгээр хавсралт.

ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ДҮГНЭХ ЖУРАМ

Нэг. Ерөнхий зүйл

- 1.1. Энэхүү журмын зорилго Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 12.2-т заасан ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч /цаашид "ТЗЭ" гэх/ тэй байгуулсан тусгай зөвшөөрлийн гэрээний биелэлт, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг дүгнэх, үнэлэх, тайлагнах, харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. ТЗЭ нь тусгай зөвшөөрөлд заасан үйл ажиллагааны техник, санхүү, эдийн засгийн байдалд үнэлгээ хийхэд шаардлагатай судалгаа, мэдээллийг Зохицуулах зөвлөлийн шаардсанаар цаг тухайд нь үнэн зөвөөр гаргаж ирүүлнэ.
- 1.3. Тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагын хүрээнд ТЗЭ-тэй байгуулсан гэрээний биелэлт, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг тухайн ТЗЭ аж ахуйн нэгж байгууллагын инженер, техникийн, санхүүгийн ажилтан дүгнэж ирүүлнэ.

Хоёр. Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг дүгнэх

- 2.1. Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг "Ус хангамжийн барилга, байгууламжийн ашиглалтын менежмент болон ашиглалт үйлчилгээний түвшинг үнэлэх аргачлал" /MNS ISO 24512:2012/, "Ариутгах татуургын барилга, байгууламжийн ашиглалтын менежмент болон ашиглалт үйлчилгээний түвшинг үнэлэх аргачлал" /MNS ISO 24511:2012/-ыг тус тус үндэслэн боловсруулж, ТЗЭ аж ахуйн нэгж, байгууллагуудын ус хангамж, ариутгах татуургын үйлчилгээний хүртээмж, цэвэр ус олборлолт, түгээлт, бохир ус татан зайлуулалт, цэвэрлэх байгууламжийн цэвэрлэгээний түвшин, байгууллагын боловсон хүчний болон санхүүгийн үзүүлэлт тус бүрээр үнэлж, дүгнэнэ. Зохицуулах зөвлөлөөс эдгээр үзүүлэлтийг нэмж буюу хасч болно.
- 2.2. ТЗЭ нь өөрийн үйл ажиллагааны гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийн биелэлтийг нэгдүгээр хавсралтын дагуу жил бүр дүгнэж, Зохицуулах зөвлөлд тайлагнана.
- 2.3. Зохицуулах зөвлөлийн ажлын алба Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг журмын гуравдугаар хавсралтын дагуу үзүүлэлт тус бүрээр хянан баталгаажуулж, ногоон, шар, улаан өнгөөр тодорхойлох бөгөөд хувьд шилжүүлэхдээ ногоон өнгө 100%, шар 50%, улаан 0% гэж тооцон, тухайн ТЗЭ-ийн гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийн нийлбэр оноог хувиар гаргана.

Гурав. Тусгай зөвшөөрлийн гэрээний биелэлт дүгнэх

- 3.1. ТЗЭ нь Зохицуулах зөвлөлтэй байгуулсан гүйцэтгэлийн гэрээний биелэлтийг хоёрдугаар хавсралтын дагуу жил бүр дүгнэж, Зохицуулах зөвлөлд тайлагнана.
- 3.2. ТЗЭ нь гүйцэтгэлийн гэрээнд тусгагдсан ТЗЭ-ийн эрх, үүргийн хүрээнд тухайн жилд хэрэгжүүлсэн үйл ажиллагааг тодорхой бичиж, холбогдох тушаал, шийдвэрийн дугаар, гарсан үр дүнг баримтжуулсан байна.
- 3.3. Биелэлтийг тухайн үзүүлэлтийн ач холбогдол, хамрах хүрээнээс нь хамааруулан 10-20 хүртэлх оноо өгч дүгнэх бөгөөд нийт оноог хувьд шилжүүлэн тооцож тухайн ТЗЭ-ийн гэрээний биелэлтийн хувь тодорхойлогдоно.

Дөрөв. ТЗЭ-ийн үйл ажиллагааг үнэлэх

- 4.1. ТЗЭ нь үйл ажиллагааныхаа түвшинг үнэлүүлэхдээ гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг нэгдүгээр хавсралт, гэрээний биелэлтийг хоёрдугаар хавсралтын дагуу тодорхойлж, тайлан мэдээний хамт жил бүрийн 02 дугаар сарын 20-ны дотор Зохицуулах зөвлөлд ирүүлнэ.
- 4.2. Зохицуулах зөвлөл нь ТЗЭ-ээс ирүүлсэн гэрээний биелэлт, Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтүүдийн дүнг нэгтгэн дараах байдлаар дүгнэж, тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хавсралтад тэмдэглэнэ.

Хүснэгт №1

№	Гүйцэтгэлийн биелэлт /хувиар/	Үнэлгээ
1	90-100	Хангалттай сайн
2	75-89	Хангалттай
3	61-74	Дунд
4	0-60	Хангалтгүй

- 4.3. Ус хангамж, ариутгах татуургын үйл ажиллагааг бусад үйл ажиллагаатай хавсран эрхэлж буй тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн хувьд зөвхөн ус хангамж, ариутгах татуургын үйл ажиллагааны үзүүлэлтүүдийг дүгнэнэ.
- 4.4. ТЗЭ-ийн үйл ажиллагааны үр дүнгийн үнэлгээг жил бүрийн 03 дугаар сард багтаан Зохицуулах зөвлөлийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлнэ.

Тусгай зөвшөөрлийн гүйцэтгэлийн гэрээний биелэлт дүгнэх маягт

А. УБ хот болон аймаг, орон нутгийн УХАТ-ын ашиглалт, үйлчилгээ эрхлэгч ТЗЭ-ч байгууллагууд

ТЗЭ-чийн нэр:

№	Гэрээний заалт	Биелэлт	Дээд оноо %/
1.	Аж ахуйн нэгж, байгууллагынхаа үйл ажиллагааны стратеги болон бизнес төлөвлөгөөг батлан мөрдөж ажиллана.		15
2.	Холбогдох хууль тогтоомж болон эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас батлан гаргасан дүрэм, журмыг чанд биелүүлэн, үйлчилгээний чанар, стандартыг мөрдөж, хэрэглэгчийн эрх ашгийг дээдлэн ажиллана.		10
3.	Үйл ажиллагааны болон санхүү эдийн засгийн тайлан мэдээг батлагдсан загварын дагуу тогтоосон хугацаанд Зохицуулах зөвлөлд ирүүлж, гэрээний биелэлтийг дүгнүүлнэ.		10
4.	Үйл ажиллагаа явуулахдаа хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нөхцөл шаардлагыг хангаж, нийт ажилтан, албан хаагчдын хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааг ханган ажиллана.		10
5.	Зохицуулах зөвлөлөөс тогтоосон хуваарийн дагуу тусгай зөвшөөрлийн зохицуулалтын үйлчилгээний хөлсийг хугацаанд нь төлнө.		10
6.	Тусгай зөвшөөрөлд заасан үйл ажиллагаанаас олох орлогын төлөвлөгөөг жил бүрийн 12 дугаар сарын 01-ний дотор Зохицуулах зөвлөлд ирүүлнэ.		10
7.	Эх үүсвэрийн болон зөөврийн ус хангамжтай ус түгээх байрны усан сан, ус хадгалах савны цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлтийг MNS 5775:2007 стандартын дагуу улирал тутам хийж, акт үйлдэн баримтжуулах бөгөөд лабораториор хянан баталгаажуулсан тухай тэмдэглэл хөтөлнө.		15
8.	Ус түгээх байраар дамжин хэрэглэгчдийг хангаж буй ундны усны эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлыг бүрэн хариуцаж, хяналт тавьж ажиллана.		10
9.	Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.6-д заасан нөхцөл байдал үүссэн, өөрийн хариуцдаг орон сууцны барилга болон үйлчилгээг бусдад шилжүүлэх, шинээр орон сууцны барилгын ашиглалт, засвар, үйлчилгээг хариуцахаар хүлээн авсан бол Зохицуулах зөвлөлд албан ёсоор тухай бүр мэдэгдэнэ.		5
10.	Байгууллага өөрийн гэсэн цахим хуудастай байх.		5
НИЙТ ОНОО %/			100%

Биелэлт гаргасан: ТЗЭ-ийн нэр дарга, захирал

Тамга тэмдэг

Тусгай зөвшөөрлийн гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт дүгнэх загвар

Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Гүйцэтгэлийн үзүүлэлтийн статус		
		Ногоон	Шар	Улаан
Баталгаат ундны усаар хангагдсан хүн амын эзлэх хувь (ТЗЭ-ийн үйлчилгээнд хамрагдсан хүн амын эзлэх хувь)-судалгаа				
Ундны усны чанарын түвшин	%	0=..		0<..
Тоолууржилтын түвшин	Орон нутаг	%	100=	75<...<100 75>
	УБ хот	%	100=	100>...
Цэвэр усны нэгж уртад ногдох гэмтлийн тоо-судалгаа				
Бохир усны цэвэрлэгээний түвшин	Умбуур бодис	%	90=<...	75=<...<90 75>..
	Биологийн хэрэгцээт хүчилтөрөгч БХХ ₅	%	90=<...	75=<...<90 75>..
	Химийн хэрэгцээт хүчилтөрөгч ХХХ ₅	%	90=<...	75=<...<90 75>...
Боловсон хүчний бүрдэлт	%	30=<..	30>...>=20	20>...
Үйлчилгээний хүртээмж	хүн	200=<...<=250.	250<...<=300	300<...<=200
1м ³ усанд зарцуулсан цахилгаан эрчим хүч	Цэвэр ус олборлоход	кВт.ц	буурсан	өөрчлөгдөөгүй ихэссэн
	Бохир ус цэвэрлэхэд	кВт.ц	буурсан	өөрчлөгдөөгүй ихэссэн
Орлого болоогүй ус	Цэвэр	%	5>=...	5=<...<18 18>...
	Бохир	%	10>=...	10=<...<20 20>...
Нэг хүний хоногт хэрэглэж буй усны хэмжээ-судалгаа	Орон сууцны хэрэглэгч	л/хон		
	Гэр хорооллын хэрэглэгч	л/хон		
Борлуулсан 1м ³ усанд ногдох үйл ажиллагааны зардал	Аймаг, орон нутаг	төг	=<1500	1500< ...=<2000 2000< ..
	УБ хот		=<600	600< ...=<1000 1000< ..
Борлуулалтын орлогын шаардагдах хэмжээ	%	...=1	1.0<...=<1.05	...>1.05
Орлогын нэг төгрөгт ногдох зардал	төг	...=<1.0	1.0< ...=<1.15	.. >1.15
Авлага цуглуулалт	%	95=<...	85<...<95	85>...
НИЙТ ОНОО %/				

1. ГШҮ=ГТҮ (КРІ) гэж юу вэ?



КРІ-н философи

...“Хэрэв та ямар нэгэн юмыг удирдахыг оролдож байвал эхлээд түүнийгээ хэмжих чадвартай байх ёстой”.



MEASURE
SUCCESS



УХАТ-ын салбарт КPI-г нэвтрүүлэх зорилго:

1. Ус хангамж ариутгах татуургын чиглэлээр ажиллаж байгаа Тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт тавих, гүйцэтгэлд нь үнэлэлт өгөх,
2. Адил төстэй бусад байгууллагатай харьцуулах,
3. Үйлчилгээний чанарын түвшинг тодорхойлох, олон улсын стандартад ойртуулах,
4. Удирдлагын шийдвэр гаргахад дэмжлэг болгох, салбарын болон байгууллагын хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох,
5. Олон нийтэд үйл ажиллагаагаа таниулан нээлттэй ажиллах,



2. Яагаад ГШҮ гэж?



KPI бол менежментийн амин чухал хэрэгсэл

Зөв ГШҮ-үүд нь таны нүдийг нээж, асуудал хаана байгааг тод харуулна. “Хэмжигдэж байгаа зүйлс л хийгдэнэ”, “Хэмжиж чадахгүй байна гэдэг бол удирдаж чадахгүй байна гэсэн үг” гэх зэргээр зөв хэмжүүр ашиглахын ач тусыг олон талаар тайлбарлаж иржээ. Зөв үзүүлэлтээ мэдэхгүй менежер хүн сохор далайчинтай адил юм.



Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт-2015

Гүйцэтгэлийн үзүүлэлт		Хэмжих нэгж	Гүйцэтгэлийн үзүүлэлтийн статус			
			Ногоон	Шар	Улаан	
1	Орлого болоогүй ус NRW	Хөдөө орон нутаг	≤ 18	$18 < \dots < 40$	$40 \leq$	
		ОСНААУГ-УБ	%	≤ 8	$8 < \dots < 15$	$15 \leq$
2	Орлогын 1 төгрөгт ногдох зардал		Төг	≤ 0.1	$0.1 < \dots \leq 1.2$	$1.2 <$
3	Борлуулсан 1 м ³ усанд ногдох үйл ажиллагааны зардал	Хөдөө орон нутаг	Төг	≤ 1000	$1000 < \dots \leq 1850$	$1850 <$
				≤ 800	$800 < \dots \leq 900$	$900 <$
4	1м ³ усанд ноогдох эрчим хүчний зардал	Хөдөө орон нутаг	Төг	≤ 210	$210 < \dots < 450$	$450 \leq$
				≤ 20	$20 < \dots < 35$	$35 \leq$
5	Тоолууржилтын түвшин	Хөдөө орон нутаг		100=	$70 \leq \dots < 100$	$70 <$
			%	100=	$50 \leq \dots < 100$	$50 <$
6	Мэргэжилтэй боловсон хүчин		%	$70 \leq$	$50 \leq \dots < 70$	< 50
7	1000 хэрэглэгчдэд ноогдох ажиллагсдын тоо		Төг	≤ 15	$15 < \dots \leq 30$	$30 <$

№	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Биелэлт	Гүйцэтгэлийн үзүүлэлтийн статус		
				Ногоон	Шар	Улаан
10	Олборлосон ус, тогтоосон нөөцийн харьцаа	%		50= \leq	50= \leq ... $<$ 70	$<$ 70
11	1м3 ус олборлоход зарцуулсан эрчим хүч	Квт.ц				
12	Борлуулалтын орлогын шаардлагат хэмжээ Бош	%		80= \leq	60= \leq ... $<$ 80	$<$ 60
13	Цэвэр усны шугам сүлжээнд ногдох гэмтлийн тоо					
14	Авлага цуглуулалт	%		95= \leq	85= \leq ... $<$ 95	$<$ 85
НИЙТ ОНОО /%/						

Шинэчлэн батлагдсан ГШҮ

1. Баталгаат ундны усаар хангагдсан хүн амын
ЭЗЛЭХ ХУВЬ

$$PP_{ASDWS} = P_{ASDWS} / N * 100\%$$

PP_{ASDWS} - Баталгаат ундны усаар хангагдсан хүн
амын эзлэх хувь, %

P_{ASDWS} – Тухайн орон нутагт ТЗЭ-ээр үйлчлүүлж буй
хүн амын тоо, жилийн эцсээр

N - Тухайн орон нутгийн хүн амын тоо, жилийн
эцсээр

Шинэчлэн батлагдсан ГШҮ

2. Ундны усны чанар

$$K_o = N_b / N_a * 100\%$$

N_a – жилд авсан шинжилгээний тоо,

N_b – Стандартад нийцээгүй дүнгийн тоо,

K_o – Стандартын шаардлага хангаагүй тохиолдлын эзлэх хувь, %

д/д	Утга	Үзүүлэлт	
		ногоон	улаан
1	Ундны усны чанар	0=	0<

Шинэчлэн батлагдсан ГШҮ

3. Тоолууржилтын түвшин

$$K_t = K_{тнх} / K_{нх} * 100\%$$

K_t – тоолууржилт, %

$K_{тнх}$ – тоолууртай нийт хэрэглэгчийн тоо,

$K_{нх}$ – нийт хэрэглэгчийн тоо,

Утга		Үзүүлэлт		
		ногоон	шар	улаан
Тоолууржилт	Орон нутагт	100=	75=<...<100	75>
	Улаанбаатарт	100=		100>...

д/д	Утга	Үзүүлэлт		
		ногоон	шар	улаан
1	Тоолууржилтын түвшин	100% тоолууртай эсвэл урьд оныхоос 5% -тай тэнцүү буюу дээш хувь тоолууржуулсан $5 \leq$	5-аас бага хувь тоолууржуулсан $5 > \dots > 0$	0 тэнцүү буюу тоолууржуулах ажил хийгдээгүй $0 =$

Шинэчлэн батлагдсан ГШҮ

4. Цэвэр усны нэгж уртад ногдох гэмтлийн тоо

$$D_{bn} = \frac{L_b}{N_b}$$

D_b - 1 гэмтэлд ногдох шугамын урт

N_b - Гэмтлийн тоо

L_b - Цэвэр усны шугамын урт, км



Шинэчлэн батлагдсан ГШҮ

5. Бохир усны цэвэрлэгээний түвшин

д/д	Утга	Үзүүлэлт		
		ногоон	шар	улаан
1	Умбуур бодис, мг/л	90= $<$	75= $< \dots < 90$	75> $> \dots$
2	Биологийн хэрэгцээт хүчилтөрөгч, мг/л	90= $<$	75= $< \dots < 90$	75> $> \dots$
3	Химийн хэрэгцээт хүчилтөрөгч, мг/л	90= $<$	75= $< \dots < 90$	75> $> \dots$

Шинэчлэн батлагдсан ГШҮ

6. Боловсон хүчний үзүүлэлт

$$K_{HR} = \frac{K_{ЗМ}}{K_{НЗМ}} \times 100\%,$$



K_{HR} -боловсон хүчний үзүүлэлт

$K_{ЗМ}$ -Зөвлөх, мэргэшсэн зэрэгтэй ИТА болон санхүүгийн ажилтны тоо

$K_{НЗМ}$ -Нийт ИТА болон санхүүгийн ажилтны тоо

д/д	Утга	Үзүүлэлт		
		ногоон	шар	улаан
1	Боловсон хүчний бүрдэлт	30 =<	30>...>=20	20>

Шинэчлэн батлагдсан ГШҮ

7. Үйлчилгээний хүртээмж, 1000 хэрэглэгчид ногдох ажиллагсдын тоо

$$YX = \frac{K_{a\theta}}{K_{AT}}$$

YX-Үйлчилгээний хүртээмж, хүн

$K_{a\theta}$ -Нийт айл өрхийн тоо

K_{AT} -Нийт засварчны тоо



д/д	Утга	Үзүүлэлт		
		ногоон	шар	улаан
1	Үйлчилгээний хүртээмж	$200 = < \dots = < 250$	$250 < \dots \leq 300$	$300 < \dots < 200$

Шинэчлэн батлагдсан ГШҮ

8. 1м3 ус олборлон дамжуулахад зарцуулсан цахилгаан эрчим хүч

$$E_p = \frac{E_c}{Q} \times 100\%$$

E_p -1м3 ус олборлон дамжуулахад зарцуулсан цахилгаан, эрчим хүч

Q - Олборлосон ус, м3

E_c – нийт зарцуулсан эрчим хүч квт.ц

Утга	Үзүүлэлт		
	ногоон	шар	улаан
1м3 ус олборлоход зарцуулсан цахилгаан эрчим хүч	буурсан	өөрчлөгдөөгүй	өссөн

Шинэчлэн батлагдсан ГШҮ

9. 1м3 бохир ус татан зайлуулж, цэвэрлэхэд зарцуулсан цахилгаан эрчим хүч

$$E_p = \frac{Z_{ц}}{Ц_y} \times 100\%$$

E_p -1м3 бохир усыг цэвэршүүлэхэд зарцуулсан цахилгааны зардал

$Z_{ц}$ -Цахилгааны зардал, мян.төг

$Ц_y$ -Цэвэрлэсэн ус, мян.м3

Утга	Үзүүлэлт		
	ногоон	шар	улаан
1м3 бохир ус татан зайлуулж, цэвэрлэхэд зарцуулсан цахилгаан эрчим хүч	буурсан	өөрчлөгдөөгүй	өссөн

Шинэчлэн батлагдсан ГШҮ

10. Шахсан борлуулсан усны харьцаа /орлого болоогүй цэвэр ус/

$$NRW_{ц} = \frac{K_{o,x} - K_{б}}{K_{o,x}} \times 100\%,$$

$NRW_{ц}$ -орлого болоогүй цэвэр ус, хувь

$K_{o,x}$ -Олборлосон буюу худалдан авсан ус, м³

$K_{б}$ -Борлуулсан ус, м³

Утга	Үзүүлэлт		
	ногоон	шар	улаан
Шахсан, борлуулсан усны харьцаа,%	5 >=	5 < ... < 18	18 <

Шинэчлэн батлагдсан ГШҮ

11. Орлого болоогүй бохир ус

$$NRWб = \frac{K_{цү} - K_{нү}}{K_{цү}} \times 100\%,$$

NRWб-орлого болоогүй бохир ус, хувь

$K_{цү}$ -цэвэрлэсэн бохир ус, мЗ

$K_{нү}$ -Нэхэмжилсэн бохир ус, мЗ

д/д	Утга	Үзүүлэлт		
		ногоон	шар	улаан
1	Орлого болоогүй бохир ус, %	10 \geq	10 $<$... \leq 20	20 $<$

Шинэчлэн батлагдсан ГШҮ

12. Нэг хүний хоногт хэрэглэж буй усны хэмжээ

Орон сууц, гэр хороололд суугчдын хоногийн усны бодит хэрэглээг тодорхойлох ба хэрэглээний зохист нормд хүргэх зорилготой үзүүлэлт

Шинэчлэн батлагдсан ГШҮ

13. Борлуулалтын орлогын шаардагдах хэмжээ, %

Утга	Үзүүлэлт		
	ногоон	шар	улаан
Борлуулалтын орлогын шаардагдах хэмжээ	Бош=1	1.0< БОш=<1.05	БОш>1.0 5

Шинэчлэн батлагдсан ГШҮ

14. Борлуулсан 1м³ усанд ногдох үйл ажиллагааны зардал, төг

Утга		Үзүүлэлт		
		ногоон	шар	улаан
Борлуулсан 1м ³ усанд ноогдох үйл ажиллагааны зардал	Орон нутагт	≤ 1500	$1500 < \dots \leq 2000$	$2000 < \dots$
	Улаанбаатарт	≤ 600	$1500 < \dots \leq 2000$	$2000 < \dots$

Шинэчлэн батлагдсан ГШҮ

15. Орлогын нэг төгрөгт ногдох зардал, төг

Утга	Үзүүлэлт		
	ногоон	шар	улаан
Орлогын нэг төгрөгт ногдох зардал	$\dots \leq 1.0$	$1.0 < \dots \leq 1.15$	$\dots > 1.15$

Шинэчлэн батлагдсан ГШҮ

16. Авлага цуглуулалт, %

$$Ав = М / (В) \times 100\%$$

Ав-Авлагын харьцаа, хувиар

М - Бэлэн мөнгөний орлого, мян.төг

В -Борлуулалтын нийт орлого, мян.төг

Утга	Үзүүлэлт		
	ногоон	шар	улаан
Авлага цуглуулалт, %	95=<...	85=<=<95	85>...

*Анхаарал хандуулсанд
баярлалаа*

2018 он

